



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/441

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 10 дугаар хуралдааны 10/06 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтанд Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.8-д 16 дугаар цэцэрлэгийн барилгын газар чөлөөлөх зардал /Жаргалант сум/ тусгагдсан тул Жаргалант сумын Наран багийн 24 дүгээр гудамжны 086 тоот байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалтай 4175 метр квадрат газрыг 000004871, 000004872 дугаар гэрчилгээгээр боловсролын байгууллагад шилжүүлэн авсаныг үндэслэн иргэн Дамбийн Батсүхэд газар чөлөөлөлтийн зардлыг олгосугай.

2.Дээрх төсөл арга хэмжээнд зарцуулах 70 000 000 төгрөг /Далан сая/ - ийг төгрөгийг Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/441 Ch
02 01959